

ҮЙЛДҮҮЛЭХ, ҮЙЛДЭГДЭХ ХЭВИЙН
ДАГАВАР БҮХИЙ ХАМ БҮТЦИЙН УТГЫН ОНЦЛОГ

Б.Мөнгөнцэцэг

Түлхүүр үг: хэлний ба хэлний бус хүчин зүйл, ижил бүтэц, хувилбар бүтэц, утгын ялгамжаа

Ямар нэг үйлийг үйлдэгчийг хамгийн идэвхтэйгээс нь хамгийн идэвхгүй рүү нь эрэмбэлбэл, хамгийн идэвхтэй үйлдэгч нь хүн, удаах нь амьтан, хамгийн идэвхгүй үйлдэгч нь юм болно. Тэгвэл хэл зүйн харьцаа заах зарим нөхцөл, өгүүлбэрийн ижил бүрэлдүүлбэр, ижил бүтцэд тохиолдох хам байгууламжид илрэх утга үүргийн ялгамжааг нарийвчлан тодорхойлоход үйлдэгчийн энэхүү идэвхтэй, дундаж, идэвхгүй шинж нэлээд учир холбогдолтой байна. Өөрөөр хэлбэл, бид хэл зүйн нэг төрлийн буюу ижил харьцаанд илрэх утгыг тодорхойлохдоо хэлний ба хэлний бус хамааралт үзэгдэл, зүй тогтол ямар учир холбогдолтой байгааг тодорхой жишээн дээр шинжлэн тайлбарлахыг зорьсон юм. Учир нь, аливаа хэлний хэл зүйн зүй тогтол нь тухайн хэлийг төрөлх хэлээ болгосон хүний танин мэдэхүй, ухамсрын төлөв байдлыг хэл зүйн, цөөн тодорхой хүрээнд барих хандлагатай байдаг бол хүний танин мэдэхүйн хязгааргүй боломж, ялангуяа нэг зүйл, юм үзэгдэл, шинж чанарыг түүнтэй аль нэг талаараа шууд ба дам холбоо хамааралтай, эсвэл түүнтэй төдий л холбоо хамааралгүй өөр бусад юм үзэгдэл, үйл байдал, шинж чанартай шүтэлцүүлэн олон талаас нь таньж мэдсэн, ойлгож ухаарсны нарийн ялгамжааг хэл зүйн тэдгээр тогтсон, нэг төрлийн хүрээг ашиглан, түүний дотоодод утгын бас нэгэн шаталсан дэд бүтэц байгууламж, дэд хамаарал, тогтолцоо үүсгэн тэмдэглэж байгааг тусгайлан шинжлэх шаардлагатай байгаа юм.

Ялангуяа XX зууны хоёрдугаар хагасаас эхлэн хэлний үзэгдэл баримтыг хүн төвт хараа, хүн төвт хэмжүүр хэмжээсээр үзэж хардаг, шинжилж нягталдаг болсноор Хүн төвт хэлшинжлэл, хүн төвт хэмжүүр хэлшинжлэлд нэвтрэх болсон нь энэ чиглэлийн судалгааны шинэ парадигм болж, улмаар хэлний илэрхийллийн утгыг урьд нь гагцхүү хэл шинжлэлийн ухааны хүрээнд шийдвэрлэх төдийгөөр сэтгэл ханан зогсдог байсан бол одоо тэдгээрийн зарим нарийн төвөгтэй асуудал, тэр тусмаа хэлний тогтвортой нэгж (өвөрмөц хэллэг буюу Idiom, хэвшмэл хэллэг буюу Proverb-ийн аль алиныг багталцуулан үзэж байна)-ийн утгыг судлан тайлбарлахдаа Хүн судлал, Сэтгэл судлал, Нийгэм судлал, Угсаа судлал, Соёл судлал, Танихуй судлал зэрэг Хүмүүнлэгийн ухаануудын уулзвар дээр авч үздэг болсон нь судалгааны цар хүрээг өргөтгөхийн зэрэгцээ, судалгааны объектийн мөн чанарыг нээж илрүүлэхэд ихээхэн дөхөмтэй болж байна (Баянсан, 2016).

Хэлний аливаа илэрхийлэл, тэр тусмаа хэлний хийсвэрлэлийн хамгийн дээд эрэмбийн үзэгдэл баримтад зүй ёсоор хамаарах хэлц нэгжийн утга үүсэх, түүнийг ойлгох хэл-сэтгэцийн оньсыг загварчлан тайлах асуудал нь нэн эдрээтэй болохын хувьд түүнд арга зүйн ямар өргөтгөл хийх ёстой бэ? гэдэг асуудал судлаачдын сэтгэлийг эзэмдэж ирсэн нь тодорхой байдаг. Тухайлбал, Кофенский (1985) хэлний илэрхийллийн утгын бүрэлдүүлбэрийг бүрэн илрүүлэхдээ хүн төвт үзэл баримтлалыг чиг болговол дараах загвар тохиромжтой болно гэжээ. Энэ нь Хэл


- Хэвшмэл хэрэглээ (узус)¹ - Хэлэхүйн үйл ажиллагаа - Журамламал хэрэглээ (норм) - Хэлэхүй хэмээгч парадигм байж болно гэж томъёолсон байна. Ф.де Соссюрийн гурвалсан бүтэц (хэл (langue), хэлэхүйн үйл ажиллагаа (language), хэлэхүй (parole))-ээс тооны хувиар олон буюу таван бүрэлдүүлбэртэй байна. Гэвч энэ бол зөвхөн тооны ялгаа төдий биш, агуулгын бүтцийг тайлбарлахад нэлээн зохимжтой нэгэн томъёолол гэдгийг В.Н.Телия (1991) бас чухалчилж үзсэн байна.

Хэлний энэ үзэгдлийг бид монгол хэлний үйлдүүлэх, үйлдэгдэх хэв оролцсон хам бүтцээр жишээлэн тайлбарлаж нотлохыг зорьж байна.

Монгол хэлний үйлдэгдэх хэв нь тусах үйл үгийг эс тусах, үйлдэлдэх хэв нь тусах ба эс тусах үйл үгийг эс тусах, үйлдүүлэх хэв нь тусах ба эс тусах үйл үгийг тусах үйл үг болгон хувиргах тул үйлийн эзэн нь нэрлэхээс гадна өгөх орших, заах, үйлдэх (хамтрах)-ын тийн ялгалаар хэлбэржинэ. Энэ бүхэн нь өгүүлбэрийн хувилбарыг бүтээх ба уул хэв бүхий өгүүлбэр нь нийлмэл өгүүлбэрийн шинжтэй байдаг. Жишээ нь: “Би дүүгээрээ зураг зурууллаа” гэвэл “Би зураг зурууллаа. Дүү зураг зурлаа” гэсэн хоёр өгүүлбэрийг багтаасан байна. Өгүүлбэр хэвийн залгавраар хувирахыг К.С.Ивченков, Г.Д.Санжеев, П.Бямбасан, Д.Отгонсүрэн нар нарийн судалжээ. Үйлдүүлэх хэвээс шалтгаалж өгүүлбэрийн бүрэлдэхүүнд ямар бүрэлдүүлэгчид байх, тэдгээр нь ямар ямар тохиолдолд заах, өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэрждэгийг эрдэмтэд судлан тайлбарласан байна. Тухайлбал, К.С.Ивченков үйлдүүлэх хэвийн дагавартай тусах үйл үгээс шалтгаалж өгүүлбэрийн бүтцэд оролцож байгаа шууд бус субъект (үйлийн эзэн) ямар тохиолдолд үйлдэх, ямар тохиолдолд өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржихийг үйлдүүлэх хэвийн дагавраар хэлбэржсэн тусах үйл үг нэг бүрийн шинжид эрж, үйлдүүлэх хэвээр хэлбэржсэн тусах үйл үгийг шууд бус субъектээ үйлдэхийн тийн ялгалаар захирдаг тусах-үйлдүүлэх үйл үг, шууд бус субъектээ өгөх оршихын тийн ялгалаар захирдаг тусах-үйлдүүлэх үйл үг гэж хоёр хуваагаад тус бүр 40 гаруй үг жагсаасны (1958:128-130, 135, 136) дотор асуулгах, бичүүлэх, дуудуулах, алуулах, дээрэмдүүлэх, зодуулах гэх мэт дурдсан хоёр тийн ялгалын аль алианаар захирч чадах олон үг байна.

Г.Д.Санжеев үйлдүүлэх хэвийн дагавраар хэлбэржсэн үйл үгээр илэрч байгаа үйлийг жинхэнэ гүйцэтгэгчийг зааж байгаа үг ямар тохиолдолд заах, өгөх орших, үйлдэхийн тийн ялгалын алианаар нь хэлбэржихийг үйл үг, нэр үг хоёрын утга учир, тийн ялгалы нь утга учиртай холбон тайлбарлажээ (1963:34-41).

П.Бямбасан үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрт сэдэх эзэн нь нэрлэх ба хааяа гарахын тийн ялгалаар, үйл гүйцэтгэгч эзэн нь өгөх орших, заах, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржинэ гээд



гэсэн хувилбар өгүүлбэр үүснэ гэжээ. Харин “Хүн ус урсгав” гэхэд шууд тусагдахуун нь учир зүйн үүднээс уг үйлийг жинхэнэ гүйцэтгэгч нь болох учраас эс тусах үйлдүүлэх хэллэгийн жинхэнэ гүйцэтгэгч эзэн нь заахын тийн ялгалаар хэлбэржинэ (2006:151) гэжээ. Д.Отгонсүрэн “эс тусах-үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрийн жинхэнэ эзэн нь заахын тийн ялгалаар (Ээж дүүг долоон цагт босгов), тусах-үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрийн жинхэнэ эзэн нь хэн нэгнээр ямар нэг юм хийлгэсэн утгатай бол үйлдэхийн тийн ялгалаар (Аав надаар тоо бодуулав), хэн нэгнийг ямар нэг юм хийхэд хүргэсэн утгатай бол өгөх оршихын тийн ялгалаар (Багш хүүхдэд кино үзүүлэв)” (1982:162) тус тус хэлбэрждэг болохыг тодорхойлжээ.

¹ Хэвшмэл хэрэглээ буюу узус гэдэг нь түгээмэл харилцаанд хэдийгээр хэрэглэгддэггүй ч гэсэн бас байх цагтаа байж болох үзэгдлийг багталцуулсан хэлний гэмдгийн нийлц гэж үзэж болно (Баянсан 2016:173).

Е.А.Кузьменков монгол хэлний үйл үгийн хэвийн дагаврыг судлаад “Хэвийн дагавар нь өөртөө үг зүй, өгүүлбэр зүй, утга зүйг агуулсан бүтээвэр юм. Хэв нь өгүүлбэр үүсэхтэй холбогдоно” (1984:77) гэжээ.

Ийнхүү хэвийн залгавар нь өгүүлбэрийг хувиргах гол хэрэглүүр болдгийг нэлээд сайн судалжээ. Хэвийн залгавар өгүүлбэрийн хувилбар хэрхэн үүсгэдгийг авч үзье.

Үйлдүүлэх хэв:

- а. Бат ном уншив- Эгч Батаар ном уншуулав.- Эгч Батад ном уншуулав
- б. Бат унтжээ- Эмч Батыг унтуулжээ- Эмч Батыг тариагаар унтуулжээ (Тариа Батыг унтуулжээ)
- в. Бат тоо бодов- Эгч Батаар тоо бодуулав- (Эгч Батыг тоо бордуулав- Эгч Батад тоо бодуулав)
- г. Бат ирэв- Ах нь Батыг ирүүлэв- Ах нь Батыг мориор ирүүлэв (Морь нь Батыг ирүүлэв)
- д. Цамц хатав- Дүү цамц хатаав- Би дүүгээр цамц хатаалгав (Отгонсүрэн, 1982:74)

Үйлдэгдэх хэв:

- а. Шарга ингэ уяагаа тайлжээ- Шарга ингэний уяа тайлагджээ- (Уяа нь шарга ингэд тайлагджээ)
- б. Би гэрээ санаж байна- Надад гэр минь санагдаж байна.
- в. Би хүчинд автагдав- Би хүчээр (шахалтаар) автагдав- (Хүч намайг авав)

Түүнчлэн монгол хэлний судлалд үйлдүүлэх хэв, үйлдэгдэх хэв хоёр ойролцоо утгатай, үйлдүүлэх хэв үйлдэгдэх хэвийн оронд хэрэглэгддэг. Энэ нь үйлдэгдэх хэв үйлдүүлэх хэвээс гарсантай холбоотой гэж үздэг. Тэгээд ямар тохиолдолд энэ хоёр хэв нэг нь нөгөөгийнхөө оронд нөхөн хэрэглэгддэгийг тодорхойлж байна. Энэ тухайд П.Бямбасан “...иймэрхүү зүйлийг нэг нь нөгөөгийнхөө оронд хэрэглэгдэж байгаа бүр ижил утга, үүрэгтэй хоёр өөр хэлбэр гэж үзэж арай болохгүй мэт санагдана. ...Хэрэв өгүүлэгч этгээд адуу салхины хүчинд автагдсанд санаагаа төвлөрүүлбэл үйл үгээ үйлдэгдэх хэвээр, өөр зүйлд санаагаа төвлөрүүлсэн бол үйлдүүлэх хэвээр хэлбэржүүлнэ. Энэ нь хэв тус бүрийн утга үүргээс болох юм” (2006:156-157) гэж үзсэн байна.

Одоо монгол хэлний үйлдүүлэх, үйлдэгдэх хэв оролцсон хам бүтэц бол утгын ерөнхий шинжээрээ, жишээлбэл, англи хэлний идэвхтэй (active), идэвхгүй (passive) хэлбэр, орос хэлний үйлдүүлэх (побудительный), үйлдэгдэх (страдательный) хэв зэрэг үзэгдэлтэй дүйдэг боловч харилцааны орчин нөхцөлөөс шалтгаалж, олон хувилбар бүтэцтэй болж, ингэхийн хэрээр олон зүйлийн утга илэрхийлдэг, түүнийг нь төрөл ба төрөл бус хэлний дээр тэмдэглэсэн харгалзах үзэгдэлтэй утга дүйлгэн оруулах цагт ээдрээтэй асуудалтай тулгарахын зэрэгцээ зарим хувилбар бүтцийн далд утгыг төрөлх хэлтэнд ч гэсэн нарийн ойлгуулахад бэрхшээл тулгарах нь бий учраас уг асуудлыг нэлээд олон хувилбар жишээн дээр үндэслэж тайлбарлахыг зорьж байна. Жишээгээр тодруулъя.

(1) Чононд бариулсан хонь, эсвэл (2) Чононд баригдсан хонь гэж үйл үгийг нь үйлдүүлэх, эсвэл үйлдэгдэх хэвээр хэлбэржүүлсэн хоёр хувилбар бүхий холбоо үг, өгүүлбэр үүсгэж болно. Уг хоёр өгүүлбэрт үйлийг үйлдэгч эзэн, үйлэнд өртөгч юм хоёул амьд амьтан (чоно, хонь) байна. Чоно хонийг барьж идэх нь байгалийн шалгарал учраас энэ хоёр өгүүлбэрийн алинаар хэлсэн ч утга хоёрдох зүйл төдий л үгүй гэж болно. Гэтэл үйлийн субъект, объект хоёрын аль аль нь дээрхийн адил амьд амьтан бөгөөд бүтэц нь ч ижил бас нэг хувилбар авъя. Жишээлбэл, (3) Бүргэдэд үнэг бариулжээ. (4) Бүргэдэд үнэг баригджээ гэх мэт. Эдгээр өгүүлбэрийн утгыг ерөнхийд нь ажиглавал, байгалийн шалгарал зохилдлогын үүднээс үнэг бүргэдэд хэдийгээр баригдаж болох учраас (3), (4) өгүүлбэр ерөнхийдөө ижил утгатай мэт боловч утгыг нь

нарийвчилбал, үнэг гэгч тэр зальт амьтан бүргэдэд бариулсныг (3) үзвэл сэрэмж алдсанаас болсон бөгөөд харин бүргэдэд баригдсан (4)-ыг үзвэл нэг талаас, үнэг ов заль гаргаж, хэчнээн зугатаасан ч бүргэдийн саварт орсон, нөгөө талаас, анч бүргэд “санамсаргүй”, гэнэт үнэгэн дээр буусны аль нь ч байж болох авч барих, баригдахын шалгарал зохилдлого буюу “хүчтэний дэргэд хүчгүй нь буруутах”-ын үлгэр болжээ гэж тус бүр утгын өнгө аяс нь ялгавартай байгааг мэдэж болно. Бас нэг зүйлийг тэмдэглэвэл, (3) өгүүлбэрийг хувилгаж (5) “Бүргэдээр үнэг бариулсан” гэвэл бүргэдийг үнэг барихад сургаж дасгасан гэсэн утга илэрхийлж болно. Харин (1) өгүүлбэрийг (6) “Чоноор хонь бариулсан” гэж хувиргавал чоно урьд нь яагаад хонийг барьж чадахгүй байсан юм бол? гэж эргэлзэхэд хүрч болзошгүй. Өөрөөр хэлбэл, субъект объектийн аль аль нь амьд амьтан ч гэсэн тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлыг хүн хэрхэн тусгасан онцлогоос хамаарч ижил бүтэц, хувирмал бүтцийн хооронд утгын ялгамжаа үүсч байгаа нь хэлний хэл зүйн бүтэцтэй хамаагүй, харин хэлний бус хүчин зүйлээс хамаатай байгаа нь мэдэгдэнэ. Дээрх (5), (6) бүтцийг үлгэр болгож зохиосон (7) Доржоор хонь бариулав гэсэн өгүүлбэрийн субъект нь хүн, харин объект нь амьтан байна. Тэгвэл (8) Доржоор мод бариулав гэхэд субъект нь хүн, объект нь юм байгаа бөгөөд бүтэц нь яг ижил байна. Гэтэл хонь хэдийгээр тухайн цагтаа хүнээс хурдан, бас булжимхай авч ухаант хүний гараас гарахгүйн хувьд яаж ийгээд хүнд баригдсаныг (7) өгүүлбэрээр илэрхийлсэн байна. Энэ өгүүлбэрийн утгыг зөв ойлгохын тулд энд хүн, амьтан хоёрын харьцаа хамаатал байгааг мартаж болохгүй. Тэгвэл Дорж модыг барих дуртай байсан эсэх нь хамаагүй модыг барихыг шаардах, хүсэхийн аль нэг аргаар Доржийн гарт модыг атгуулсан буюу түүгээр мод бариулсан хэмээсэн утгыг (8) өгүүлбэрээр илэрхийлжээ. Энэ өгүүлбэрийн утгыг зөв тайлахын тулд тухайн өгүүлбэрт хүн, юм хоёрын харьцаа хамаатал байгааг бас зайлшгүй анзаарах хэрэгтэй болно.

Аливаа юм үзэгдэл, шинж чанар, байдал нөхцөлийг жинхэнэ ёсоор таньж мэдэх, ойлгож ухаарах гэдэг бол чухамдаа тэдгээрийн хоорондох харьцааг л зөв мэдэрч ойлгохыг хэлдэг байна. Чингээд аливаа юмын харьцааг зөв оноон ойлгох нь уг юмыг бүрэн дүүрэн таньж мэдэх гол арга болдгоороо ач холбогдолтой ажээ. Бидний дээр жишээлэн авсан “(2) Чононд баригдсан хонь, (4) Бүргэдэд үнэг баригджээ” гэхэд байгалиас заяасан хоёр амьтны харьцах харьцааны боломж нь нэг нь давуу, нөгөөх нь хүчинд автагдсан, тэгш бус харьцаатай байна. Үүнийг үйлийн жинхэнэ гүйцэтгэгч нь нэг нь нөгөөгийнхөө харьяалалд багтах, үйлдэл нь тэгш харьцаатай өөр нэгэн хувилбар бүтцүүдтэй харьцуулъя.

Бас нэг жишээ авъя.

- (1) Ард олондоо хүрээлэгдсэн хүн.
- (2) Ард олноороо хүрээлэгдсэн хүн.
- (3) Ард олноороо хүрээлүүлсэн хүн.
- (4) Ард олондоо хүрээлүүлсэн хүн.

Дээрх дөрвөн хувилбар нь ерөнхийдөө нэг утга санааг илэрхийлдэг ч гэсэн өөр хоорондоо утгын ялгамжаатай юм. Өөрөөр хэлбэл, (Уг) хүнийг ард олон хүрээлдэг буюу адилхан хүндэтгэдэг/ дээдэлдэг гэсэн утга санаа нь тэдгээр хувилбарын нийтлэг тал болно. Үйлийн субъект нь хоёулаа “хүн” (хүн, ард олон) болно. Харин хувилбар үүсгэхдээ үйлийн үндсийг үйлдүүлэх, үйлдэгдэх хэвийн дагавраар тус тус хэлбэржүүлснээр “хүрээлэх” үйлийн эзэн- “ард олон” гэх үгийн хэл зүйн хэлбэржилт нь өгөх орших, эсвэл үйлдэхийн тийн ялгалаар харгалзан хэлбэржсэн хувилбар бүтэц үүссэн байна. (1) өгүүлбэрийн ард олон нь илүү идэвхтэй, “хүн” нь түүнээсээ харьцангуй сул идэвхтэй буюу “хүн” нь өөрөө сайн хүн болж үзэгдэх гээгүй, эсрэгээрээ ард олон нь өөрийн эрхгүй түүнийг эрхэмлэн хүндэтгэх, дээдлэн хүрээлэх утгатай болно. Харин (3) өгүүлбэрийн хоёр субъект харилцан хэм тэнцүүвтэр үйлдэх харьцааг илэрхийлнэ. Тэгвэл (2) өгүүлбэр нь журамламал хэрэглээний үүднээс зохисгүйвтэр

мэт сэтгэгдэвч (1) өгүүлбэрийн утгатай харьцуулбал “хүн” нь бүр илүү идэвх султайг илтгэж байна. Үүнийг “тороор хүрээлэгдсэн шувуу” гэдэг ижил бүтцийн утгатай харьцуулан үзэж болно. Тэгвэл (4), (1) хоёр нь үйлийнхээ хэвийн хэлбэржилтээрээ л ялгарч, бусад бүрэлдүүлбэр нь ижил байх бөгөөд (4) өгүүлбэрийн “хүн” нь (1) өгүүлбэрийн “хүн”-ийг бодоход арай илүү идэвхтэй гэж болно.

Тодорхой болгох үүднээс,

(1) Усанд хүрээлэгдсэн адуу

(2) Усаар хүрээлэгдсэн газар

(3) Усаар хүрээлүүлсэн газар

(4) Усанд хүрээлүүлсэн адуу

гэсэн өөр нэг хувилбар бүтцүүдийн утгыг өөр хооронд нь харьцуулж, дараа нь дээрх (1, 4) хувилбарын утгын ялгамжааг тодорхойлох үндэслэгээ болгоё.

Монгол хэлний тусах үйл үгийн зарим нь зохиогч өгүүлэгч чухам юуг голлон өгүүлж байгаагаас шалтгаалан идэвхтэй, идэвхгүй хэвийн алинаар ч хэлэх нь бий. “Ус адууг хүрээлсэн” гэвэл усыг онцлон өгүүлсэн, (1) Усанд хүрээлэгдсэн адуу гэвэл адууны тухай онцлон өгүүлж байгаа буюу адуу усны эрхшээлд орсон утгыг илтгэж байна. Үүнийг хувилбар (4)-ийн “адуу”-тай харьцуулбал идэвхгүй, хөдөлгөөн муутайг илтгэж байна. Тэгвэл хувилбар (4)-ийн адуу нь (2)-ийнхоос арай илүү идэвхтэй хэдий ч ус адууг эрхшээсэн утгатай байна. (2), (3)-ийн субъект, объектийн аль аль нь юм хэдий ч хувилбар (3) нь усны хүч их байсны улмаас ус арлыг хүрээлсэн, харин (2) нь усны дунд орших утгыг илтгэнэ.

Үүнээс үзэхэд, хэл зүйн бүтцийн талаас ямар ч харшлах зүйл үгүй атал утга зохисгүйдэж байгаа нь хэлний бус хүчин зүйлээс хамаарч байна. Чингээд монгол хэлний үйлдэгдэх, үйлдүүлэх хэвээр хэлбэржүүлсэн үйл үгэнд үйлдэх, өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржүүлэн холбосон холбоо үг бүхий хувилбартай өгүүлбэрүүдийн утгын ялгамжааг тодорхойлохдоо тухайн өгүүлбэр дэх субъект, объект нь Хүн-Хүн, Хүн-Амьтан, Хүн-Юм, Амьтан-Амьтан, Амьтан- Юм, Юм- Юмын алин байхаас тэдгээрийн эрхшээх үйл ялгавартай болж, түүнийг илэрхийлэх зарим боломж нь хэдийгээр хэлний хэл зүйн бүтцийн хүрээнд захирагдавч, утгын ялгамжаа нь хэлний бус хүчин зүйлээр нөхөцмөл, шалтгаалтай байна.

Abstract

In this paper, the author aims to explain regularities and linguistic and non-linguistic factors in defining differences in meaning manifested by the same grammatical relations, examples of constructions containing causative voice.

The description of sentence meaning and subject and object depend on whether the subject and object are Person-Person, Person-Animal, Person-Thing, Animal-Animal, Animal-Thing, Thing-Thing. Though the means of expression obey grammatical structures, it can be concluded that differences in meaning may be restricted by non-linguistic matters.

This is crucial to defining detailed differences in the meaning and function of suffixes indicating grammatical relations, equivalent sentence components, and structures. In particular, from the viewpoint of grammatical structure, exemplified sentences may be correct in form but semantically inappropriate due to non-linguistic factors.

Номзүй

- Баянсан Ж.** 2016. *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Уб.
- Бямбасан П.** 2006. *Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв, байдал*. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Уб.
- Ивченков К.С.** 1958. *Субъективно-объективные отношение в монгольском побудительном обороте*. Филология и история монгольских народов. Москва.
- Кофinsky.** 1985. *J Ke vzťahum ovesný a specialne lingvistický teorie systém*. K princíp pom marxistickej jazykovedy. Bratislava.
- Кузьменков Е.А.** 1984. *Глагол в монгольском языке*. Ленинград.
- Санжеев Г.Д.** 1963. *Сравнительная грамматика монгольских языков (Глагол)*. Москва.
- Телия В.Н.** 1991. *Механизмы экспрессивной окраски языковых единиц*. Человеческие факторы в языке: Языковые механизмы экспрессивности. Москва.
- Отгонсүрэн Д.** 1982. *Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв байдлын найруулгын үүрэг*. Уб.